

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-10-20

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 10 дугаар сарын 28-ны “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс 2024, 2025 онуудад өгсөн бүх үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргаж, удаашралтай байгаа ажлуудын шалтгаан нөхцөлийг танилцуулах.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
2	Нийтийн тээврийн зорчилтыг нэмэгдүүлж, зардлаа бууруулах ажлыг зохион байгуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
3	2026 онд камержуулах ажлуудынхаа төлөвлөлтийг танилцуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, “Багахангайн теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
4	“Авто зогсоол менежмент”-ийн ажлаа эрчимжүүлж, танилцуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
5	Ус түгээх болон баруун, төвийн эх үүсвэрүүдийн худгуудын усны тарифыг урьдчилсан байдлаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Ус суваг ашиглалтын товчоо
6	Усны нөөцийн зөвлөлийг өөрчлөх хуулийн төслийг боловсруулж, танилцуулах.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
7	Дугуйн замыг авто замын төслүүдтэй уялдуулах талаар танилцуулах.	Дүүргийн менежер, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
8	Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэр дэх явган замыг цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
9	Давс, бодис нөөцлөх ажлыг эрчимжүүлж, аж ахуйн нэгж, байгууллагууд хариуцсан талбайн цас, мөсийг тухай бүр шуурхай цэвэрлүүлж, халтиргаа гулгаа үүсгэхгүй байхад анхаарч ажиллах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, ААНБ
10	Инженер хангамжийн байгууллагууд иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс,

	хүчээр найдвартай хангаж, тасалдуулахгүй байхад онцгой анхаарч, бэлэн байдлыг хангах.	Дэд бүтцийн байгууллагууд
11	Хүүхэд, багачуудад зориулсан цогц ажлуудаа зохион байгуулах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
12	Сурагчдын бие даалт, амралтын өдрүүдэд угаарын хийн хордлого, гал түймрийн аюул, осол болон бусад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх ажлыг зохион байгуулах.	Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төв
13	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цогц арга хэмжээ авч ажиллах.	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс
14	“Хотула” аппликейшний үйл ажиллагаа, хөгжүүлэлтийг жигдрүүлж, нийслэлийн байгууллагуудын удирдлага, албан хаагч нар хэрэглэж хэвших, мэдээлэл солилцдог байх.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, хэвлэл мэдээлэл
15	Дүүргүүд камерын хяналтын дэд төвүүдээр автозам, явган замын халтиргаа гулгааг тогтмол хянах, зөрчлийн талаар мэдээлж байхаар журамлах.	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, “Багахангайн теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
16	Хойд жигүүрийн халаалтын шугамын хөрсний нөхөн сэргээлтийн ажлыг сайжруулах /хөрсийг тэгшлэх, явган замын хавтан сэргээж тавих/	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Илч-Орд ОНӨААТҮГ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
17	Нарийн ногооны хэрэглээний статистик тооцоолол гаргах	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Статистик
18	Нийслэлийн Санхүү төрийн сангийн газрын уулзалтын хуваарийг судлах, танилцуулах мэдээллийг бэлтгэх	Засаг даргын Тамгын газрын дарга, Дүүргийн менежер, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
19	Хөрөнгө оруулалтаар хийгдэх биохими, спортын хэрэглэл, 94 дүгээр сургуулийн зуух, 20 машины граж, гэрэлтүүлэг, эрчим хүчийг нэмэгдүүлэх ажлыг яаралтай хүлээн авах	Санхүү төрийн сангийн хэлтэс, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
20	Дүүргийн хөгжлийн чуулганы бэлтгэлийг сайтар хангаж, урилга, постер бэлтгэн Нийслэлийн цахим хаяг /Улаанбаатар мэдээ/-т байршуулах	Засаг даргын Тамгын газрын дарга, Дүүргийн чуулган зохион байгуулах ажлын хэсэг, Хэвлэл мэдээлэл
21	Багахангай-2040 бодлогын баримт бичигт тусгасан судалгааны тайланг бэлтгэн танилцуулах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
22	Багахангай-Хөшигтийн хөндийн Төмөр замын хөрсний нөхөн сэргээлт, худгийн ашиглалт хамгаалалттай танилцах, холбогдох албан бичиг бэлтгэн хүргүүлэх	Дүүргийн менежер, Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, хэвлэл мэдээлэл
23	Түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах зөвшөөрөл хүсэх талаар хотын даргад албан хүсэлт хүргүүлэх	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
24	“Иргэд олон нийтийн сэтгэл ханамжийн судалгаа”-нд иргэд, албан хаагчид, ахмад настан, ТЗ-ын албан хаагчдыг бүрэн хамруулах, судалгаанд хамруулах албан	Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хороод, ААНБ

	бичиг хүргүүлэх	
25	Нийслэлийн Засаг дарга 2025.12.10 нд дүүрэгт ирж ажиллахтай холбогдуулан бэлтгэл ажлын бүрэн хангах	Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
26	Боловсролын байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээг ахиулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан танилцуулах	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс
27	Efekta demo англи хэлний түвшин сайжруулах аппликейшний албан хаагчид, хүүхэд залуучуудад таниулах, албан хаагчдын мейл хаягийн бүртгэлийг цуглуулах	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
28	2025 оны төсвийн гүйцэтгэлийг танилцуулах, эрх нээгдсэн ажлуудыг шуурхай зохион байгуулах, дутуу ажлуудыг тодорхойлох, гүйцэтгэх, төлөвлөх	Санхүү төрийн сангийн хэлтэс, ААНБ

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ